



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/65

Арвайхээр

Буцалтгүй тусламж үзүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, аймгийн Засаг даргын 2012 оны а/113 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн 5.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргад хандаж тусламж хүсч өргөдөл ирүүлсэн Өлзийт сумын 4 дүгээр багийн Засаг дарга Б.Баярхүүгийн хүү Б.Норовренчин нь тархины хавдар гэж оношлогдон Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй, гадаадад эмчилгээ хийлгэх шаардлагатай тул эмчилгээний зардалд 3,000,000 (гурван сая), Уянга сумын 5 дугаар багийн иргэн Б.Шийрэвсүрэнгийн гэр нь шатаж хүүхдийн амь нас эрсдсэн тул 2,000,000 (хоёр сая)төгрөгийн буцалтгүй тусламжийг тус тус үзүүлсүгэй.

2.Дээрх зардал болох 5,000,000 (таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100142